

ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЛЭЭ ТӨВТЭЙ БОЛОВСРУУЛАХ НЬ

О.Алтангэрэл, ШУТИС

Abstract

As curriculum is an official document to assess educational results, its theory, concepts and design for development affect to academic objectives and consequences. Some requirements to develop curriculum are put into account in modern society with the orientation of the world education, social demand and up-to-date approaches in learning. Similarly, some objectives to conduct a broader research in curriculum development in terms of enhancing scientific concepts in earth grounded circumstance.

This paper aimed to recommend a methodology of Applied Learning Curriculum, undertaking comparative analysis on concepts and design of curriculum development with the demand of education quality that focuses on developing learners' generic knowledge and skills in authentic contexts and providing opportunities to explore their career aspirations and orientation for life-long learning in specific areas. The applied learning curriculum is an entire system of acquiring adequate knowledge, skills and values, attitudes with a variety of professional field to develop their career aspirations. The significance of the research paper was to define the framework of the professional application in particular field and characteristics of the applied learning curriculum.

Түлхүүр үг

Хичээлийн хөтөлбөрийн төв, мэдлэгийн хэрэглээ, сургалтын зорилт, эрэлт хэрэгцээ, үйлийн баримжаа, хэрэглээ төв

Удиртгал

Сургалт нь хүмүүний нийгэмд амьдрах хэрэгцээнээс урган гарсан зорилт, тулгарсан асуудлаа шийдвэрлэх чадвар, арга туршлага, дадал эзэмшиж, байгалаас заяасан төрмөл чанараа хөгжүүлэх үйл явц бөгөөд түүний үндсэн үүрэг, зорилго нь нийгэм ба бие хүний хөгжин байх эрэлт, хэрэгцээг хангах асуудал юм.

Сургалтын үүрэг, зорилго, зорилт нь хувь хүний ба нийгмийн хөгжлийн чиг хандлага зэргээс нөхцөлдөн, эрэлт-хэрэгцээ, захиалга хэлбэрээр илэрдэг. Сургалтын зорилго, зорилтыг илэрхийлэх хэрэгсэл, сурах-сургах үйлийг удирдан чиглүүлэх үндсэн баримт бичиг нь хичээлийн хөтөлбөр юм. Иймээс хичээлийн хөтөлбөрийг хэрхэн оновчтой боловсруулах вэ? гэсэн асуудал өнөөг хүртэл судлаачдын анхаарлыг татсан хэвээр байна. Нийгэм, бие хүний сурч, хөгжих хэрэгцээг хөтөлбөрт хэрхэн тусгах, амьдралаас урган гарч, байнга хувьсан өөрчлөгдөж буй шинэ эрэлт хэрэгцээтэй яаж уялдуулах, хөтөлбөрийн чанарыг юугаар, хэрхэн үнэлэх зэрэг асуудлууд орчин үеийн дээд боловсролын зорилтуудаас урган гарна (Шүрэв, Түвшинжаргал, Гэндэнжамц ба бусад 2017). “Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтийн чанарын үнэлгээг хэрэгжүүлэх механизмыг төгөлдөржүүлэх” гэсэн нь сургалтын хөтөлбөрийн талаарх судалгааг иж бүрнээр өргөжүүлэх шаардлагатайг харуулж

байна. Нийгмийн харилцааны өрсөлдөөнт байдлаас аливаа сургалтын чанарын талыг илүүтэй шаардах боллоо. Боловсролын чанар нь ерөнхий утгаараа хувь хүнээс цаг хугацааны ба хэрэгцээний өөрчлөлтөд дасан зохицох чадамжаар хэмжигдэнэ. Түүний үндсэн үзүүлэлт нь эзэмшсэн мэдлэг чадвараа амьдрал, практикийн асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэх хэрэглээний түвшин мөн. Боловсрол хүмүүнлэг шинж чанартай байх, хүн төвтэй байх хандлагын талаас үзвэл сургалтын туйлын зорилго нь мэдлэг биш хүн, түүний хөгжил, дэвшил байх шаардлагатай. Үүнээс үндэслэн боловсрол, сургалтын бүхий л үйл явцыг зохион байгуулах, түүний дотор хичээлийн хөтөлбөр боловсруулах суурь үзэл баримтлал нь суралцагчийн өөрийн үйл ажиллагаанд түшиглэх конструктив онол, суралцагчийн эрэлт хэрэгцээнд чиглэсэн прагматик арга зүйд төвлөрсөн, бусад үзэл баримтлалын реконструктив хослол байх юм. Дээрх онолын үүднээс аливаа мэдлэгийг чадвар, дадал болгон хөгжүүлэхийн тулд тухайн субъект өөрөө материаллаг болон оюун сэтгэхүйн хүрээнд тодорхой үйл гүйцэтгэх шаардлага үүсдэг. Үүгээр мэдлэг субъектээс субъектэд шууд шилжиж, дамждаг зүйл биш, хүний өөрийн үйл ажиллагаагаар бүтээгддэг болох нь батлагддаг. Энэ нь сургалтын хөтөлбөр боловсруулах, сурах

*  Soyombo_alt2000@yahoo.com

аргазүй, технологийг тодорхойлоход зарчмын өөр хандлагыг шаардаж байна.

Хүний үйл ажиллагаа нь сэрэл, хүртэхүйгээр дамжин хийгдэх материаллаг болон дээд шатандаа хийсвэр сэтгэхүйгээр хийгдэх оюуны гэсэн үндсэн хоёр хэлбэртэйг сэтгэл зүйчид баталсан. Түүнчлэн статик төлөвтөө үйл ажиллагаа нь үйлээс, үйл нь үйлдлүүдийн харилцан нөхцөлдсөн тогтолцоог үүсгэж байдаг. Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг суралцагчийн “үйл ажиллагааны тогтолцоо” гэж үзвэл, хөтөлбөрийн агуулгын нэгж элементүүд дараагийн төвшний элементийг судлахад чиглэсэн тодорхой хэрэглээний зорилтыг нөхцөлдүүлж, мэдлэг эзэмшихүйн материаллаг ба оюун сэтгэхүйн хоёр төвшинт үйлийн явцад хэрэглээ болж чадваржсан цогц чадвар, дадал, улмаар тухайн мэдлэгийг ашиглаж гүйцэтгэх үйлийн баримжаа болон төлөвшиж, суралцагчийн оюуны дотоод ахуйд мэдлэгийн шинэ бүтцийн хэлбэрээр бүтээгдэнэ.

Гальперин П.Я, аливаа үйл ажиллагааны үр дүнг тодорхойлогч нэг нөхцөл нь тухайн үйлийн тодорхой чанарын ертөнц бүхий дүрийг санаанд төлөвшүүлж байдаг сэтгэцийн үйлийн өвөрмөц хэлбэр болох субъектийн баримжаа гэж үздэг (Гальперин, 1977, х.54-55). Энэ нь эзэмшсэн мэдлэг чадвараа ашиглан ажил, үйлийг гүйцэтгэх

хүний оюун санаан дах дүр зураг, тусгал, батжин бэхэжсэн мэдрэлийн холбоос, сэтгэхүй дэх бодит зүйл юм. Талызина Н.Ф үйлийн ойлгомжтой байх шинж нь гүйцэтгэгч хүнээс тэдгээрт байгаа гол нөхцөлүүдийг баримжаалах байдлаар тодорхойлогдоно (Талызина, 1982, х-60). Сургалтаар мэдлэгийг хэрэглээ болгож (чадвар, дадал) эзэмшүүлэхийн сэтгэц физиологийн үндэс нь суралцагчийг материаллаг (сэрэл, хүртэхүйн) ба оюуны дотоод (сэтгэхүйн) үйлүүдэд татан оролцуулах замаар тэдний эрэлт хэрэгцээ болсон үйл ажиллагааны “субъектийн баримжааг” төлөвшүүлэхэд оршино. Иймээс энэ чадваржсан цогц мэдлэг “үйлийн баримжаа” нь үйл ажиллагааны тодорхой талбар-хүрээнд зорилтот үйлийг гүйцэтгэхэд хүрэлцээтэй, хангалттай байх ба дараагийн төвшний цогц чадваржсан мэдлэгийн хөгжлийн суурь болж байдаг. Танин мэдэхүй, суралцахуйн сэтгэц, физиологийн үндсийг ингэж тайлбарласнаар суралцагсад мэдлэгээ бүтээж байхуйцаар сургалтыг төлөвлөж, оновчтой зохион байгуулах, субъектийн хөгжлийг чиглүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм. Хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад баримталж байгаа зарим үзэл баримтлалыг харьцуулбал:(Жадамбаа, 1998). (Хүснэгт 1).

Хүснэгт 1

Хичээлийн хөтөлбөрийн харьцуулалт

Хөтөлбөрийн үзэл баримтлалууд	Хөтөлбөрийн шинж чанар	Онцлог, ялгаа
Судлагдахуун төвтэй	ШУ-ны системт бүтэц, дараалал бүхий судлагдахуун	Системлэг бүтэц
Чадвар төвтэй	Тодорхой чадвар, технологид чиглэсэн судлагдахуун,	Тодорхой хэрэгцээнд чиглэсэн
Хүний хөгжил төвт	Бие хүний хөгжлийн тусгай чанаруудыг хөгжүүлэх	Хувь хүний онцлогийг харгалзах
Нийгмийн функц, үйл ажиллагаа төвт	Нийгмийн тодорхой хэрэгцээ	Нийгмийн хэрэгцээг харгалзах
Хувь хүний хэрэгцээ, сонирхол төвт	Суралцагч хувь хүний сонирхол, хэрэгцээ	Хувь хүний хэрэгцээнд чиглэх


Хөтөлбөрийн эдгээр үзэл баримтлалын онцлог, давуу талуудад тулгуурлан, боловсролын өнөөгийн шаардлагыг харгалзан үзвэл, сургалтын хөтөлбөр нь нийгэм ба бие хүний хэрэгцээнд тулгуурлан, судлагдахуун, туршлагын асуудал нь хэрэглээнд орж байх, хэрэгцээний өөрчлөлттэй уялдсан хувьсал бүхий, уян хатан байх шаардлагатай юм.

Сургалтаар юуны тулд яах гэж, юуг, хэнд, хэзээ, яаж сурч сургаад, ямар нөлөө үзүүлэх гэсэн асуудлыг шийдвэрлэдэг. Үүнээс үндэслэн

хичээлийн хөтөлбөрийг зорилго, зорилт, агуулга (судлагдахууны хүрээ), хэрэглэгдэхүүн, аргазүй, үнэлгээ, дүгнэлт гэж бүтэцлэдэг.

Хөтөлбөрийн тогтолцоог бүрдүүлэгч элементүүдийн харилцан уялдааг рациональ, цикл, динамик буюу харилцан үйлчлэлийн гэсэн загвараар тодорхойлсон байна (Б. Жадамбаа, 1998) (Зураг 2, 3, 4).


Зураг 2
Рациональ загвар



Зураг 4
Динамик загвар




Зураг 3
Цикл загвар



Хичээлийн хөтөлбөрийн рациональ, цикл, динамик загваруудын ашигтай талын хослолд хичээлийн хөтөлбөрийг мэргэжилтний үйл ажиллагааны хүрээ, түүний зорилтуудаас үндэслэн мэдлэг чадварын хэрэглээнд төвлөрсөн баримжааллаар хөдлөнгө, хувьсал өөрчлөлт бүхий бүтэц загвараар боловсруулах боломжтой (Зураг 5).

Зураг 5
Хичээлийн хөтөлбөрийг хэрэглээ төвтэй боловсруулах үйл ажиллагааны дараалал



Хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын хамгийн эхний чухал үе шат нь түүний зорилгыг тодорхойлох асуудал. Энэ нь хөтөлбөрийг ямар үзэл баримтлал, зарчимд тулгуурлаж байгаатай холбоотой. Хэрэглээ төвтэй, хөдлөнгө (уян хатан, өөрчлөлт хувьсал бүхий) хөтөлбөрийн зорилгыг тодорхойлоход сургалтын хүмүүнлэг, суралцагч төвтэй байх зарчмыг үндэс болгох боломжтой. Энэ үүднээс хөтөлбөрийн зорилго нь бие хүний хөгжил, эрэлт хэрэгцээнд төвлөрч, дараах шаардлагад тулгуурлах юм.


- Хөтөлбөрийн зорилго тухайн ШУ-ны нийгмийн болон суралцагчийн эрэлт хэрэгцээг бодитой илэрхийлж байх
- Хөтөлбөрийн зорилго нь зорилтуудаар дамжин оношлогдох, үр дүнг харьцуулан үнэлэх боломжтой байх
- Хөтөлбөрийн зорилго өнөөгийн төдийгүй, ирээдүйд чиглэсэн байх

Ихэнх тохиолдолд хөтөлбөрийн зорилго, зорилт нь дүгнэж оношлох боломж муутай, ерөнхий томъёологдож байдаг нь сургалтыг өрөөсгөл удирдлагатай, урсгал үйл явцын байдалтай болоход нөлөөлж байна. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг сургалтын алхам, үе шат бүхэнд агуулгын тодорхой нэг элементийн тухайд ч хамруулбал зохино. Энэ үндсэн дээр хөтөлбөрийн агуулга дах хэрэглэгдэхгүй мэдлэгийн хэмжээ багасаж, янз бүрийн түвшин дэх сургалтын зорилго, зорилтыг тодорхой болгох

боломжтой. “Суралцагч өөрийн сурах үйлийн ач холбогдол, зорилтыг ухамсарласан зөвхөн тэр үед л ухамсартай, идэвхтэй сургалт явагдах нөхцөл бүрдэж, зорилгод хүрэх шаардлагатай чадвар, дадлыг эзэмших бөгөөд суралцагч өөрийнхөө сурах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх болно((Алтангэрэл, 2008, х-37). Хөтөлбөрийн агуулга нийгэм, хувь хүний эрэлт хэрэгцээ сонирхол, өмнөх түвшин, шийдвэрлэх асуудалд төвлөрч, сургалтын явцад суралцагч хэрэглээ болж, чадваржсан мэдлэг (чадвар, дадал)-ийг өөрөө бүтээж, тэр нь түүний өдөр тутмын амьдрал, сурах үйл ажиллагааны явцад шууд хэрэглээнд орж, батжин, хөгждөг байх нь чухал. Энэ нь сургалтын хөтөлбөр хэрэглээ төвтэй байхын онцлог, түүний мөн чанар бөгөөд нийгэм, хувь хүний эрэлт, хэрэгцээг хичээлийн хөтөлбөрийн түвшинд буулгаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцын үе шат бүхэнд мэдлэгийг практикийн ба оюун сэтгэхүйн төвшинд хэрэглээ болж байхуйцаар төлөвлөн зохион байгуулах нь аргагүйн хувьд шинэ асуудал болно. Хөтөлбөрийн зорилго, зорилт, түүнийг нөхцөлдүүлэгч чадвар, дадлын бүтцээс үндэслэж, хөтөлбөрийн агуулгад судлагдахууны ямар элементийг оруулж, агуулгыг ямар бүтэцтэй бүрдүүлэх асуудлыг суралцагчийн хэрэгцээ, түүнд чиглэсэн хэрэглээний хүрээнд төвлөрсөн байдлаар зохиомжлон бүрдүүлэх юм. Хэрэглээ төвтэй хөтөлбөрийн судлагдахууны бүтэц, хүрээг тодорхойлох алгоритмыг үзүүлэв (Зураг 6).

Зураг 6

Хэрэглээ төвтэй хөтөлбөрийн судлагдахууны бүтэц, хүрээг тодорхойлох алгоритм



Хөтөлбөрийн зорилт нь сургалтын хөтөлбөрийн тогтолцоонд удирдан хувьсагч-тодорхойлогч үүрэгтэй элемент учир хөтөлбөрийг хэрэглээ төвтэй боловсруулах үйл ажиллагааны дэс дараалал, зохион байгуулалт, чиглэл нь зорилтоос эхэлсэн, буцах холбоо бүхий байна. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг нийгэм,

бие хүний эрэлт, хэрэгцээнд хийсэн судалгаа шинжилгээнд үндэслэн тодорхойлох ба зорилго, зорилтоос түүнийг хангах мэдлэг чадвар, дадлын бүтцийг гаргана. Тухайн мэдлэг чадвар, дадлыг ШУ-ны ямар мэдлэгийн системээр бүрдүүлэх асуудлыг хөтөлбөрийн зорилтын үүднээс тухайн элементийн хэрэглээний ач холбогдлыг үнэлэн

тооцох замаар хэрэгжүүлнэ. Сургалтын явц ба үр дүнд хийсэн дүн шинжилгээнээс үндэслэн, хөтөлбөрийн зорилттой уялдсан агуулгын бүтцэд зохих засвар тохируулга хийнэ. Энэ нь хөтөлбөрийн уян хатан, динамик шинжийг бүрдүүлнэ.

Дүгнэлт

1. Нийгмийн үнэт зүйлийн өөрчлөлт, шинжлэх ухаан технологийн хөгжлийн хурд, иргэний нийгэм, бие хүний сурч сэдэх, хийж бүтээх шинэ эрэлт хэрэгцээ, нийгмийн түвшин дэх боловсрол сургалтын үүрэг зорилгын өөрчлөлт зэрэг хүчин зүйлүүдтэй уялдан, хичээлийн хөтөлбөр боловсруулах аргагүйг боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.
2. Хэрэглээ төвтэй сургалтын хөтөлбөрийн тогтолцооны хэв шинж нь түүний зорилго, зорилттой харилцан нөхцөлдсөн, шүтэн барилдлага бүхий хэрэглээний тогтолцоогоор илэрхийлэгдэнэ. Үүнээс үндэслээд хөтөлбөрийн тогтолцооны төв нь тодорхой хэрэгцээ, үйл ажиллагаа, түүнд чиглэсэн мэдлэг, чадварын хэрэглээ байх учир хөтөлбөрийн судлагдахууны элемент бүр практик үйлийн ба оюун сэтгэхүйн үйлийн төвшинд хэрэглээний ач холбогдолтой байх шаардлага тавигдана.
3. Суралцагч мэдлэгийг өөртөө шинээр бүтээх, улмаар чадвар, дадлын төвшинд хөгжүүлэх үндсэн нөхцөл нь мэдлэгийн элементүүдийг хэрэглээнд оруулж, тодорхой үйл хийх асуудал болно. Мэдлэгийг хэрэглээнд оруулах үйл нь материаллаг-практик үйлийн ба сэтгэхүйн үйлийн хүрээнд явагдана. Иймээс хэрэглээний төвшинд эзэмшигдсэн мэдлэг чадвар, дадлыг төлөвшүүлэх физиологи үндэс нь сурах үйлийн явцад суралцагчийг сэтгэхүйн үйлд оруулахад орших бөгөөд энэ нь сургалтын технологийн хөгжлийн үндсэн асуудал болно.
4. Хөтөлбөрийн зорилт нь сургалтын хөтөлбөрийн тогтолцоонд удирдан хувьсагч-тодорхойлогч үүрэгтэй элемент учир сургалтын хөтөлбөрийг хэрэглээ төвтэй боловсруулах үйл ажиллагааны дэс дараалал, зохион байгуулалт, чиглэл нь зорилтоос эхэлсэн, буцах холбоо бүхий байна.

Ашигласан материал

- Жадамбаа, Б. (2003). Тэнхим дахь мэдлэг бүтээх үйл явц
- Жадамбаа, Б., бусад. (1998). Чанартай хөтөлбөр-багшийн хөгжил. Улаанбаатар
- Талызина, Н.Ф. (1982). Мэдлэг эзэмших үйл ажиллагааг удирдах нь
- Гальперин П.Я., Гальперин П.Я. (1977), *Формирование творческого мышления // Деятельность и психические процессы // Тез. докл. к V Всесоюзному съезду Общества психологов (Москва, 27 июня — 2 июля 1977 г.)* М., 1977. С. 54—55
- Алтангэрэл О, (2008), Сургалтын хөтөлбөрийг хэрэглээ төвтэй боловсруулах аргагүйн асуудал. Улаанбаатар
- Пүрэв, О., Энхтогтох, А., Түвшинжаргал, Д., ба бусад. (1977). Сургалтын хөтөлбөрийн хөгжил, судалгаа, шийдвэрлэх асуудлууд. 2017. www.itpd.mn/index.php?r=content/view&id=856